

## **ШИНЭЭР БИЙ БОЛСОН АЖЛЫН БАЙРНЫ ТАЛААР:**

2022 онд хүн амын ажилгүйдэл ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх ажлын хүрээнд төр, хувийн хэвшил болон тусгай сангудын эх үүсвэрээр шинээр 1220 ажлын байр бий болгосон. Шинээр бий болсон ажлын байрны байнгын ажлын байранд 648 иргэн, улирлын ажлын байранд 185 иргэн, түр ажлын байранд 387 иргэнийг тус бүр ажилтай болгосон байна.

Шинээр бий болсон ажлын байрыг эдийн засгийн ангиллаар нь авч үзвэл: ХАА-24.6 хувь, Боловсруулах үйлдвэр-10.4 хувь, Уул уурхай-8.9 хувь, Боловсрол-2.5 хувь, барилга-13.6 хувь, Бөөний болон жижиглэн худалдаа-12.0 хувь бусад салбарт 28.0 хувь болсон байна. Шинээр бий болсон ажлын байрны 837 нь аж ахуй нэгж, байгууллагад, 387 нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид бий болгосон байна.

2023 оны 6 дугаар сарын байдлаар төр, хувийн хэвшил болон тусгай сангудын эх үүсвэрээр тайлант хугацаанд шинээр 694 ажлын байр бий болгосон. Үүнээс шинээр бий болсон ажлын байрны байнгын ажлын байранд 362 иргэн, улирлын ажлын байранд 50 иргэн, түр ажлын байранд 282 иргэнийг тус бүр ажилтай болгосон байна.

Шинээр бий болсон ажлын байрыг эдийн засгийн ангиллаар нь авч үзвэл: ХАА-19.2 хувь, боловсруулах үйлдвэр-6.4 хувь, уул уурхай-7.1 хувь, барилга-9.1 хувь, бөөний болон жижиглэн худалдаа-10.0 хувь бусад салбарт 48.2 хувь болсон байна.

Шинээр бий болсон ажлын байрны 465 нь аж ахуй нэгж, байгууллагад, 229 нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид бий болгосон байна.